



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2025/153/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn Өмнөговь аймаг</p> <p>2025 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: Ө.Болортуяа Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.06.25 № 225
танай _____-ны № _____-г

АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.БАТДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд 149,402.6 мянган төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар, 43,287.2 мянган төгрөгийн хөрөнгийг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй зарцуулсан, 187,301.6 мянган төгрөгийн зарцуулалтад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 02 дугаар тогтоолтой нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4625020462

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Досх

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2024 оны ээлжит сонгуулиар сонгогдсон 35 төлөөлөгч, 7 зөвлөлийн гишүүн, 5 хороотойгоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хотын төвлөрлийг сааруулах, төрийн албан хаагчид орон нутагт тогтвор, суурьшилтай ажиллах нөхцөлийг баталгаажуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу 3 албан хаагчид 29,730.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 86.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,003,558.45	27,482,677.34
33	АВЛАГА	29,146,541.11	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	29,146,541.11	-
35	БАРАА МАТЕРИАЛ	32,857,017.34	27,482,677.34
354	Хангамжийн материал	32,857,017.34	27,482,677.34
35410	Бичиг хэргийн материал	5,695,150.00	3,479,500.00
35420	Аж ахуйн материал	8,238,580.00	1,649,890.00
35440	Түлш, шатах тослох материал	4,610,000.00	8,040,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,313,287.34	14,313,287.34
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,150,555,961.62	1,014,607,697.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,150,555,961.62	1,014,607,697.93
392	Биет хөрөнгө	1,149,015,961.62	1,014,387,697.77
39203	Авто-тээврийн хэрэгсэл	321,900,000.00	360,580,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(160,591,666.96)	(214,241,667.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,038,544,297.33	950,776,143.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(165,858,493.61)	(215,426,181.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,866,190.00	102,755,525.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,537,073.31)	(21,436,629.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	102,500,000.00	102,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(30,807,291.83)	(51,119,791.91)
393	Биет бус хөрөнгө	1,540,000.00	220,000.16
39301	Програм хангамж	5,500,000.00	5,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,960,000.00)	(5,279,999.84)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,212,559,520.07	1,042,090,375.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,212,559,520.07	1,042,090,375.27
51	Засгийн газрын хувь оролцоо	1,212,559,520.07	1,042,090,375.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	174,867,941.66	174,867,941.66
51101	Өмч: - төрийн	174,867,941.66	174,867,941.66
512	Хуримтлагдсан үр дүн	1,037,427,008.41	866,957,863.61
51210	Өмнөх үеийн үр дүн	1,037,427,008.41	1,037,427,008.41
51220	Тайлант үеийн үр дүн	-	(170,469,144.80)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	264,570.00	264,570.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,212,559,520.07	1,042,090,375.27

/төгрөгөөр/

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,579,219,603.72	3,351,893,070.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	983,701,799.72	75,270,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	983,701,799.72	75,270,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	34,810,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	34,810,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	980,551,799.72	38,680,300.00

**Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан**

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	3,150,000.00	1,780,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,595,517,804.00	3,276,622,770.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	374,889,904.00	563,532,370.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,841,904.00	42,532,370.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	337,048,000.00	521,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,220,627,900.00	2,713,090,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,220,627,900.00	2,713,090,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,643,748,454.99	3,522,362,214.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,643,748,454.99	3,522,362,214.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,901,649,899.49	2,832,590,159.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	352,774,724.52	589,452,509.48
210101	Үндсэн цалин	167,141,640.63	276,118,478.69
210102	Нэмэгдэл	140,657,967.85	218,295,880.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,104,000.00	45,348,000.00
210104	Урамшуулал	11,871,116.04	49,690,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,237,285.20	74,877,726.49
210201	Тэтгэврийн даатгал	32,890,718.53	51,968,775.78
210202	Тэтгэмжийн даатгал	3,850,037.76	5,997,830.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,080,030.20	3,173,095.09
210204	Ажилгүйдлийн даатгал	716,423.30	1,656,462.41
210205	Эрүүл мэндийн даатгал	7,700,075.41	12,081,563.10
2104	Хангамж, бараа материалын зардал	63,397,895.23	79,127,884.49
210401	Бичиг хэрэг	9,383,450.00	10,675,350.00
210402	Тээвэр, шатахуун	47,913,960.00	53,350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,485,485.23	4,626,044.49
210404	Ном, хэвлэл	1,615,000.00	2,892,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	7,583,690.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,670,380.00	55,813,300.00
210604	Урсгал засвар	26,202,380.00	55,813,300.00
2107	Томилолт, зочны зардал	4,384,500.00	5,066,000.00
210702	Дотоод албан томилолт	4,384,500.00	5,066,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	409,203,242.44	610,755,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	409,203,242.44	610,755,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	996,981,872.10	1,417,497,058.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	661,124,750.00	615,610,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	235,752,090.00	520,391,260.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	100,105,032.10	281,495,398.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	742,098,555.50	689,772,055.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	312,273,500.00	286,400,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	312,273,500.00	286,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,563,345.00	117,469,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,063,652.00	52,104,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	29,730,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,499,693.00	35,635,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	346,261,710.50	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	346,261,710.50	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	285,903,055.65
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	285,903,055.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	935,471,148.73	(170,469,144.80)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,000,000.00	-

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,000,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,000,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>930,471,148.73</u>	<u>(170,469,144.80)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,595,517,804.00</u>	<u>3,276,622,770.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>2,595,517,804.00</u>	<u>3,276,622,770.00</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	374,889,904.00	563,532,370.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,841,904.00	42,532,370.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	337,048,000.00	521,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,220,627,900.00	2,713,090,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,220,627,900.00	2,713,090,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,576,948,814.00</u>	<u>3,204,565,935.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>2,576,948,814.00</u>	<u>3,204,565,935.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,834,850,258.50</u>	<u>2,514,793,879.35</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	381,821,507.89	560,305,968.37
210101	Үндсэн цалин	196,188,424.00	246,971,937.58
210102	Нэмэгдэл	140,657,967.85	218,295,880.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	33,104,000.00	45,348,000.00
210104	Урамшуулал	11,871,116.04	49,690,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,337,042.94	74,877,726.49
210201	Тэтгэврийн даатгал	32,990,476.27	51,968,775.78
210202	Тэтгэмжийн даатгал	3,850,037.76	5,997,830.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,080,030.20	3,173,095.09
210204	Ажилгүйдлийн даатгал	716,423.30	1,656,462.41
210205	Эрүүл мэндийн даатгал	7,700,075.41	12,081,563.10
2104	Хангамж, бараа материалын зардал	66,920,445.23	71,973,544.49
210401	Бичиг хэрэг	11,136,500.00	8,459,700.00
210402	Тээвэр, шатахуун	48,963,960.00	55,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,844,985.23	4,626,044.49
210404	Ном, хэвлэл	1,975,000.00	2,892,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	995,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,306,680.00	55,813,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,104,300.00	-
210604	Урсгал засвар	26,202,380.00	55,813,300.00
2107	Томилолт, зочны зардал	4,384,500.00	5,066,000.00
210702	Дотоод албан томилолт	4,384,500.00	5,066,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	409,203,242.44	610,755,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	409,203,242.44	610,755,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	896,876,840.00	1,136,001,660.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	661,124,750.00	615,610,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	235,752,090.00	520,391,260.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>742,098,555.50</u>	<u>689,772,055.65</u>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	312,273,500.00	286,400,000.00

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	312,273,500.00	286,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,563,345.00	117,469,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,063,652.00	52,104,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	29,730,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,499,693.00	35,635,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	346,261,710.50	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	346,261,710.50	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	285,903,055.65
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	285,903,055.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18,568,990.00	72,056,835.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	18,568,990.00	72,056,835.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,568,990.00	72,056,835.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,568,990.00	72,056,835.00
223001	Бусад хөрөнгө	18,568,990.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	72,056,835.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(18,568,990.00)	(72,056,835.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	174,867,941.66	264,570.00	1,037,427,008.41	1,212,559,520.07
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	174,867,941.66	264,570.00	1,037,427,008.41	1,212,559,520.07
Тайлант үеийн үр дүн			(170,469,144.80)	(170,469,144.80)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	174,867,941.66	264,570.00	1,037,427,008.41	1,042,090,375.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,743,090,400.00	2,427,187,344.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,743,090,400.00	2,427,187,344.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,258,956,400.00	2,035,153,344.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590,949,000.00	533,019,418.37
210101	Үндсэн цалин	271,749,400.00	246,971,937.58
210102	Нэмэгдэл	240,000,000.00	218,295,880.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,796,000.00	45,348,000.00
210104	Урамшуулал	22,403,600.00	22,403,600.00

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,868,600.00	71,466,906.49
210201	Тэтгэврийн даатгал	50,230,600.00	49,649,418.23
210202	Тэтгэмжийн даатгал	5,909,500.00	5,724,964.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,954,800.00	2,954,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,954,700.00	1,601,890.68
210205	Эрүүл мэндийн даатгал	11,819,000.00	11,535,832.65
2104	Хангамж, бараа материалын зардал	104,500,000.00	71,973,544.49
210401	Бичиг хэрэг	14,400,000.00	8,459,700.00
210402	Тээвэр, шатахуун	76,500,000.00	55,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,600,000.00	4,626,044.49
210404	Ном, хэвлэл	3,000,000.00	2,892,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	995,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	137,100,000.00	127,870,135.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	80,000,000.00	72,056,835.00
210604	Урсгал засвар	57,100,000.00	55,813,300.00
2107	Томилолт, зочны зардал	12,000,000.00	5,066,000.00
210702	Дотоод албан томилолт	12,000,000.00	5,066,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,306,400.00	89,755,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,306,400.00	89,755,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,214,732,400.00	1,136,001,660.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	645,188,000.00	615,610,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	569,544,400.00	520,391,260.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	484,134,000.00	392,034,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	376,800,000.00	286,400,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	376,800,000.00	286,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	107,334,000.00	105,634,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,104,000.00	52,104,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,730,000.00	29,730,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,500,000.00	23,800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,743,090,400.00	2,427,187,344.35
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,743,090,400.00	2,427,187,344.35
132001	Орон нутгийн төсвөөс	2,743,090,400.00	2,427,187,344.35
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	563,532,370.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	563,532,370.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	551,697,370.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,286,550.00
210104	Урамшуулал	27,286,550.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,410,820.00

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	2,319,357.55
210202	Тэтгэмжийн даатгал	272,865.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	218,295.09
210204	Ажилгүйдлийн даатгал	54,571.73
210205	Эрүүл мэндийн даатгал	545,730.45
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	521,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	521,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,835,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,835,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,835,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	563,532,370.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	563,532,370.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,532,370.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	521,000,000.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 1,153,265.6 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

Залруулсан алдаа:

- Тайлант онд 4,120.000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал, 630.000 төгрөгийн бичиг хэргийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд дутуу илэрхийлсэн,
- Тайлант хугацаанд Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг авлагаар тайлагнаагүй,
- Өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан үр дүнгийн дахин илэрхийлсэн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өмнөх үеийн үр дүнтэй тулган баталгаажуулахад 1,037,427,008.41 төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Тайлант онд урсгал засварын зардлаас 0002-ӨМА дугаартай Ниссан Патрол автомашинд 25,077.300 төгрөгийн, 0789-ӨМҮ дугаартай Ланд крузер автомашинд 13,603.000 төгрөгийн засвар хийж гүйцэтгэсэн боловч капиталжуулж бүртгээгүй,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг Үндсэн хөрөнгийн тайлангийн худалдаж авсан хөрөнгийн дүнтэй тулгахад 72,056.835 төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 401,991.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 35,223.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул "Өөрчлөлттэй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 1 албан хаагчид 3,000.000 төгрөгийн шагнал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалт бусаар зарцуулсан 3,000.000 төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Албан шаардлага

1. Тайлант онд нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 12 албан хаагчид 16,000.000 төгрөгийн тэтгэмж, 2 албан хаагчид 6,000.000 төгрөгийн шагнал олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", "Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам"-ын 6.2./Хурлын байгууллагад 10-аас доошгүй жил тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажилласан ажилтанд тэгш насны ой, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан 2,000.000 /хоёр сая/ хүртэл төгрөгийн үнэ бүхий эд зүйлийг дурсгаж болно/, 6.4./Тухайн онд ажил хөдөлмөрөөрөө бусдыг манлайлсан нэг ажилтанг шалгаруулан дурсгалын зүйлээр шагнана/ гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант онд 43,287.240 төгрөгийн хөрөнгийг анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зарцуулсан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

3. Төсвийг зардлын эдийн засгийн ангилалын дагуу зарцуулсан эсэхийг түүвэрлэн шалгахад хичээл үйлдвэрлэлийн зардлаас 51,160.500 төгрөгийн хөрөнгийг буудлын төлбөр, соёмбо барьмал, тугны үнэ, зочдын хоолны зардалд зарцуулж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг түүвэрлэн шалгахад 75,700.000 төгрөгийн контент хийх ажлыг 10 байгууллагад хувааж гэрээ байгуулсан, 84,500.000 төгрөгийн Япон улсад туршлага судлах аялалыг шууд гэрээгээр зохион байгуулсан, 27,101.640 төгрөгийн төлөөлөгчдийн хоол, цайны зардлыг нэг байгууллагад 2 хувааж гэрээ байгуулж, сонгон шалгаруулалт гүйцэтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 02 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5. Цалингийн сангаас нягтлан бодогчид балансын урамшуулал 1,980.000 төгрөг олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Гадаад улсад туршлага судлах аялал зохион байгуулж 96,262.100 төгрөгийг хичээл хичээл үйлдвэрлэлийн зардлаас анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 15 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд 4,120.000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал, 630.000 төгрөгийн бичиг хэргийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд дутуу илэрхийлсэн	1	4,750.0			1	4,750.0	1	4,750.0				
Тайлант хугацаанд Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг авлагаар тайлагнаагүй	1	351.5			1	351.5	1	351.5				
Өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан үр дүнгийн дахин илэрхийлсэн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өмнөх үеийн үр дүнтэй тулган баталгаажуулахад 1,037,427.008.41 төгрөгөөр дутуу тайлагнасан	1	1,037,427.0			1	1,037,427.0	1	1,037,427.0				
Тайлант онд урсгал засварын зардлаас 0002-ӨМА дугаартай Ниссан Патрол автомашинд 25,077.300 төгрөгийн, 0789-ӨМҮ дугаартай Ланд крузер автомашинд 13,603.000 төгрөгийн засвар хийж гүйцэтгэсэн боловч капиталжуулж бүртгээгүй	1	38,680.3			1	38,680.3	1	38,680.3				
Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг Үндсэн хөрөнгийн тайлангийн худалдаж авсан хөрөнгийн дүнтэй тулгахад 72,056.835 төгрөгөөр дутуу илэрхийлсэн	1	72,056.8			1	72,056.8	1	72,056.8				
Дүн	5	1,153,265.6			5	1,153,265.6	5	1,153,265.6				

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 12 албан хаагчид 16,000.000 төгрөгийн тэтгэмж, 2 албан хаагчид 6,000.000 төгрөгийн шагнал олгосон	1	19,000.0			1	19,000.0								
2	Төсвийг зардлын эдийн засгийн ангилалын дагуу зарцуулсан эсэхийг түүвэрлэн шалгахад хичээл үйлдвэрлэлийн зардлаас 51,160.500 төгрөгийн хөрөнгийг буудлын төлбөр, соёмбо барьмал, тугны үнэ, зочдын хоолны зардалд зарцуулж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	1	51,160.5			1	51,160.5								
3	Тайлант онд 43,287.240 төгрөгийн хөрөнгийг анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зарцуулсан	1	43,287.2			1	43,287.2								
4	Цалингийн сангаас нягтлан бодогчид балансын урамшуулал 1,980.000 төгрөг олгосон	1	1,980.0			1	1,980.0								
5	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг түүвэрлэн шалгахад 75,700.000 төгрөгийн контент хийх ажлыг 10 байгууллагад хувааж гэрээ байгуулсан, 84,500.000 төгрөгийн Япон улсад туршлага судлах аялалыг шууд гэрээгээр зохион байгуулсан, 27,101.640 төгрөгийн төлөөлөгчдийн хоол, цайны зардлыг нэг байгууллагад 2 хувааж гэрээ байгуулж, сонгон шалгаруулалт гүйцэтгээгүй	1	187,301.6			1	187,301.6								
6	Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 19,494.000 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан	1	19,494.0			1	19,494.0								

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд
хийсэн аудитын тайлан

7	Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 75,700.000 төгрөгийн контент хийлгэсэн	1	75,700.0			1	75,700.0						
8	Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 3,200.000 төгрөгөөр уралдаан, тэмцээн зохион байгуулсан	1	3,200.0			1	3,200.0						
9	Гадаад улсад туршлага судлах аялал зохион байгуулж 96,262.100 төгрөгийг хичээл хичээл үйлдвэрлэлийн зардлаас анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй зарцуулсан	1	96,262.1					1	96,262.1				
10	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 1 албан хаагчид 3,000.000 төгрөгийн шагнал олгосон	1	3,000.0	1	3,000.0								
Дүн		10	500,385.4	1	3,000.0	8	401,123.3	1	96,262.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Хариуцлага тооцох албан шаардлага		Албан шаардлага		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
1													
	Дүн												
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
1													
	Дүн												
	Нийт дүн								-				